



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 265

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дад “хонины ноос” гэсэн бараа, түүхий эдийн нэр төрлөөр тусгай зөвшөөрөл нэмж олгох” тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 10.4, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А/35 тоот тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 1.3, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэ тогтоолын хавсралтад дурьдсан Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дад “хонины ноос” гэсэн бараа, түүхий эдийн төрлөөр Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа нэмж эрхлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн нэмж авсан зөвшөөрлийн нэг удаагийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 50,000 /тавин мянга/ төгрөгөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

030416

Санхүүгийн зохицуулах хорооны 2013  
оны 07 дугаар сарын 17-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

д/д	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн нэр	Нэмж олгох тусгай зөвшөөрөл
1	“Өлгий түүхий эд ХААБ” ХХК	1/ хонины ноос.
2	“Сантланс ХААБ” ХХК	
3	“Вүүдсоунд ХААБ” ХХК	